

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
4 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1	Хуралдааны товч тэмдэглэл	1-3
2	Дэлгэрэнгүй тэмдэглэл	4-37
	1.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд	4-26
	2.“Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнийг сонгон шалгаруулах журам батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	27-35
	3.“Комиссын гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх хугацааг тогтоох тухай” Байнгын хорооны төсөл	35-37

**Монгол Улсын Их Хурлын 2020 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
4 дүгээр сарын 15-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Х.Нямбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 26 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Л.Болд, Ц.Гарамжав, Л.Энхболд, Л.Оюун-Эрдэнэ;
Тасалсан: С.Бямбацогт, Ц.Мөнх-Оргил, С.Эрдэнэ.

Нэг.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.04.10-ны өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Г.Элбэгсайхан, Улсын дээд шүүхийн Эрүүгийн танхимын тэргүүн шүүгч Б.Цогт, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн Ажлын албаны зөвлөх О.Зандраа, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Атарцэцэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн захиргаа удирдлагын газрын дарга Ж.Сайнхишиг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах мэргэжилтэн Ш.Цолмон нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх М.Үнэнбат, зөвлөх Б.Хонгорзул, референт Ч.Батбямба, Н.Монголмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Батнасан, Ш.Раднаасэд, Ж.Батзандан нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Улсын дээд шүүхийн Эрүүгийн танхимын тэргүүн шүүгч Б.Цогт, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн Ажлын албаны зөвлөх О.Зандраа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг нар хариулж, тайлбар хийв.

Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар, О.Батнасан, Ш.Раднаасэд, Д.Ганболд нар үг хэлэв.

Х.Нямбаатар: Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Татгалзсан 4
Бүгд 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДӨР
/ЛХАГВА ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Х.Нямбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг хэлэлцэх асуудал нэг Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл, хэлэлцэх эсэхийг шийднэ.

Хоёрдугаарт Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнийг сонгон шалгаруулах журмыг батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг батална.

Гуравдугаарт хэрэв журам батлагдсан тохиолдолд Байнгын хороо Хүний эрхийн Үндэсний Комиссын сонгон шалгаруулалтыг зарласан тогтоолын төслийг бас батлахаар ийм 3 асуудлыг өнөөдөр хэлэлцүүлэхээр саналтай байна. Хэлэлцэх асуудалтай холбоотой, хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Энийг бол өнөөдөр өргөн барих эсэх асуудал яригдана. Тэгээд гишүүдээс өнөөдөр санал аваад тэгээд өргөн барих эсэх асуудлыг шийдье гэсэн. Өөр саналтай гишүүн байна уу? Саналтай гишүүн байхгүй бол хэлэлцэх асуудалд оръё. Хэлэлцэх асуудал.

Нэг.Засгийн газраас 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг хийе.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Нямдорж танилцуулна.

Ц.Нямдорж: Шүүхийн тухай хууль бол, та бүхний өдрийн амгаланг айлтгаж байна. Энэ Үндсэн хууль батлагдсанаас хойш а Их Хурал дөрөв дэх удаагаа Шүүхийн хуультай хэлэлцэж байна. 94 онд нэг хууль батлагдсан. Тэр үед Дэмбэрэлцэрэн Дээд шүүхийн дарга байсан. Шаравдорж ажлын хэсэг ахалж Дээд шүүхийнхний боловсруулсан нэг төслийг оруулж ирж батлуулж мөрдсөн. Тэрнээс 10-аад жилийн дараа 2003 онд Эрүүгийн хуулийн хууль тогтоомжийн цогц шинэчлэл хийж энэ хүрээнд 2003 онд Шүүхийн хуулийг хоёр дахь удаагаа баталсан. Энэ хоёр хууль аль, аль нь Үндсэн хуулийнхаа суурь зарчимд нийцсэн ийм хуулиуд байсан. Дараа нь 2009 онд Элбэгдорж Ерөнхийлөгч болчихоод Ерөнхийлөгчийн хувьд энэ шүүхийн хуулийг шинэчлэх ажлын хэсэг гээч юм байгуулж, тэгээд тухайн үед мөрдөж байсан хуулийг 4 хууль болгоод ингээд 2012 оноос хойш өнөөдрийг хүртэл мөрдөж байна. Энэ хугацаанд шүүхийн ажил сайжрах биш улам дордсон эмх замбараагүй байдал бий

болсон нөхцөл байдал харагдаж байна. Сая өнгөрсөн онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг оруулах үед шүүхтэй холбоотойгоос хэд хэдэн заалт орсон.

Нэгдүгээрт энийг хэрэгжүүлэх шаардлага гарсан. Хоёрдугаарт Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт энэ шүүхтэй холбоотой асуудлыг шинэчилж сайжруулна гэсэн зорилт дэвшүүлэгдсэн. Гуравдугаарт хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд бас энэ талаарх заалт туссан, зорилт дэвшүүлэгдсэн. Энэ бүхнийг иш үндэс болгоод хамгийн гол нь энэ сүүлд Үндсэн хуульд орсон өөрчлөлтийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага гарсан учраас хуулийн төслийг боловсруулсан. Арга зүйн хувьд болбол энэ 2012 онд төрөөс салгасан хуулийг нэгтгээд шүүх нэгдмэл байх ёстой гэдэг байр суурины үүднээс нэгтгэсэн нэг хууль болгож анхны төсөл гарсан. Энэ төслийг хууль хэрэглэдэг Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөлд өгөөд тэд нарын саналыг аваад ер нь тэд нарын саналд суурилж төслийг эцэслэн боловсруулсан. Манай яаман дээр ажлын хэсэг байгуулагдаж ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Дээд шүүхийн ерөнхий шүүгч, шүүгчид, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажилтнууд оролцсон. Би энэ асуудлаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Дээд шүүхийн ерөнхий шүүгч баяртай хамтад нь нэг удаа тус бүрд нь нэг удаа уулзаж, ингэж энэ төсөл эцэслэн боловсруулагдсан.

Тэгээд хамгийн сүүлд одоо энэ та нарын ойлголцсон төслийг чинь Засгийн газарт өргөн мэдүүллээ шүү гэдгийг нь мэдэгдээд Засгийн газрын хурлаар хэлэлцүүлж Их Хуралд өргөн мэдүүлсэн гэдгийг юуны урьд тэмдэглэе. Өөрөөр хэлэх юм болбол энэ төсөл болбол ажил хийж байгаа ажлаа хариуцсан гол байгууллагуудыг санал нь туссан, тэнд ажиллаж байгаа албан хаагчдын саналыг авсан ийм төсөл болсон гэдгийг би нэгдүгээрт тэмдэглэж хэлье.

Төслийн гол хэдэн зүйлийг би та бүхэнд танилцуулчих ёстой гэж бодож байна. Нэгдүгээр үндсэн асуудал болбол шүүгчдийн зөвлөгөөн гэдэг юм шинэ ойлголтыг энэ төсөлд тусгасан. Энэ шүүгчдийн зөвлөгөөн хоёр жилд нэг удаа болох. Болохдоо анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шүүгч нарын олонх нь тэгээд Улсын дээд шүүхийн шүүгчдээс бүрдсэн ийм зөвлөл хуралдана. Энэ зөвлөл үйл ажиллагааны журмыг өөрсдөө батлаад Шүүхийн ерөнхий зөвлөл мэргэжлийн болон сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгчдийг сонгох, эгүүлэн татах, шүүгчийн ёс зүйн дүрмийг батлах, Шүүхийн ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг сонсох, шүүгчдийн үйл ажиллагаатай холбоотой бусдаас асуудлыг авч хэлэлцэж зөвлөмж гаргах чиг үүргийг хэрэгжүүлэхээр туссан гэдгийг нэгдүгээрт танилцуулж байна. Бас шаардлагатай гэж үзвэл ээлжит бус хуралдаан зохион байгуулж болох гарц дотор нь бий.

Хоёрдугаарт анхан болон давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болох ийм зохицуулалтыг тусгасан. Тойргийн зарчим гэдэг нь жишээ нь анхан шатны шүүхийн тухайд Налайх, Багахангай, Багануур дүүргийн хавьд нэг анхан

шатны шүүх ажиллаад энэ гурван дүүрэг болон тэр хавьд байгаа ойр байгаа төв аймгийн шүүхийг Говьсүмбэрийг ч юм уу харьяалж болохоор ийм зохицуулалт юм байгаа нь юм. Давж заалдах шатны шүүхийн тухайд болбол зам харгууд тавигдчихсан 60, 70 километрийн зайтай ийм давж заалдах шүүхүүд байна. Аймаг бүрт. Эд нарыг тойрогчлоод нэг газарт давж заалдах шатны шүүх байгуулчих юм болбол шүүх бүрэлдэхүүний талаасаа ч тэр, нөлөөлөөд цэнхэр байх талаасаа ч тэр байр сав, хөрөнгө мөнгө хэмнэх талаасаа ч тэр үр дүн ажил болно гэж үзсэн гэдгийг танилцуулъя.

Гуравдугаарт Шүүхийн ерөнхий зөвлөлийн тухай асуудал энд нэг гол сэдэв байсан. 10 гишүүнтэй зөвлөл байхаар төсөл оруулж ирж байна. 10 гишүүнээс 5 нь шүүгч байх, 5 гишүүн, үлдсэн 5 гишүүнийг Хууль зүйн байнгын хороо 3-ыг Ерөнхийлөгч Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс тус бүр 1 байхаар ийм бүрэлдэхүүнтэй байхаар оруулж ирж байгаа гэдгийг танилцуулъя. Шүүхийн ерөнхий зөвлөл болбол ерөнхийдөө болбол одоогийн байдлаар ажиллана гэсэн ийм байр суурь баримталсан гэдгийг танилцуулж байна. 4 жилийн хугацаагаар нэг удаа эд нарыг сонгоно гэдгийг бас тэмдэглэе. Үндсэн хуулийн нэмэлтээр шүүхийн сахилгын хороо гэдэг байгууллага байхаар хуульчилсан. Энэ сахилгын хороо болбол хэр нь бие дааж ажиллах шаардлагатай гэж үзсэн. Жаахан зардал нэмэгдэнэ. Сахилгын хороо нь хуульд заасан үндэслэл журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах, сахилгын бус шийтгэл ногдуулах ийм үүрэгтэйгээр ажиллана гэдгийг хэлье.

Сахилгын хороо 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байх санал төсөлд туссан. Сахилгын хорооны эдгээр 9 гишүүнд шүүгчдийн зөвлөлөөс 4-ийг, Хууль зүйн байнгын хорооноос 3-ыг, Ерөнхийлөгчөөс 1-ийг, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс 1-ийг тус тус томилж ажиллахаар ингэж зохицуулсан гэдгийг би танилцуулж байна. Сахилгын хороонд асуудал ирэх юм болбол сахилгын хорооны гишүүн шалгаад тэгээд хуралдаж дээрх шийдвэрүүд аль нэгийг гаргах, энэ гаргачихсан шийдвэрийн талаар маргаан гаргах юм болбол энэ сахилгын хороо бүрэн бүрэлдэхүүнээрээ нэг хэлэлцээд хоёр дахь шат. Тэр сахилгын хороо эцсийн шийдвэр гаргасны дараа гомдол гарахаар болбол Улсын дээд шүүхээр хянуулахаар ийм зохицуулалтыг дотор нь туссан гэдгийг хэлье.

Сахилгын хорооны гишүүнд бас юу тавьсан мэргэжлээр арваас доошгүй жил ажилласан, шүүгч, хууль хуульчдаас бүрддэг. Бүрэн эрхийн хугацаа нь 4 жил байхаар ийм зохицуулалтыг тусгасан гэдгийг хэлье. Дараа нь шүүгчдийн мэргэжлийн хороо гэж 9 хүний бүрэлдэхүүнтэй бас нэг хороо ажиллах мэргэжлийнх нь асуудлыг авч үзэх ийм зүйлүүд байна. Шүүхийн Тамгын газартай холбогдолтой зохицуулалтууд бас энэ төсөл дотор тусгасан. Ер нь шүүхэд үйлчилдэг ийм байгууллага. Ерөнхий зөвлөл нь тамгын газраа доошоо удирдаад явчих ийм л зохицуулалт тусгасан байгаа гэдгийг бас та бүхэнд танилцуулахаар байна. Бас энэ иргэдийн төлөөлөгчтэй холбоотой

асуудал бий гэдгийг хэлье. Би товчхондоо ийм танилцуулга та бүхэнд хийж байна. Гол асуудлаар юу байвал асуулт хариулт байвал хариулаад явчихъя гэж бодож байна. Энэ бэлтгэсэн төслийг энэ нөгөө вирусийн асуудал дэгдчихсэн байсан учраас хязгаарлагдмал байдлаар санал авсан. Сайт дээр байрлуулаад нийт дүнгээрээ 41 шүүх, Шүүхийн ёс зүйн хорооны ажлын алба, Улсын ерөнхий прокурор, цагдаа, Өмгөөлөгчдийн холбоо, сайдуудаас гээд ийм саналуудыг авсан.

Бас холбогдох судалгаа хэлэлцүүлгүүд ном журмынхаа дагуу хийгдсэн гэдгийг хэлье. Хуулийн төслийн үзэл баримтлал танилцуулгыг цахим хуудсанд 20 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр байршуулсан бөгөөд үүний дагуу ирүүлсэн, иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 10 гаруй саналыг хүлээн авч төсөлд тусгасан. Энэ төслийг Хууль зүйн байнгын хороонд хүргүүлсэн санал авахаар, сүүлд нь манай ажлын хэсгийн гишүүд Нямбаатар даргатай уулзаад бас төсөл дотроо ойлголцсон гэж надад ойлгогдсон. Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн. Санал ирэлгүй нэлээн удсан. Тэгээд сүүлд нь Ерөнхийлөгч энэ төсөлтэй чинь танилцлаа гэж бичээд тэгээд энэ Хуульчдын холбоо гэдэг газраас юунд боловсруулсан гэх хоёр, гурван төслийг нь хавсаргасан байсан. Тэгэхдээ болбол тэр өргөн мэдүүлэх хэлбэрээр биш гэдгийг хэлье. Харин энэ эцэслэн боловсруулсан төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдсэний дараа тэр түрүүчийн хэлдэг 2 төслийг санал авах хэлбэрээр ирүүлчихсэн байна лээ.

Ямар ч байсан тэрийг яамдад явуулчихсан байна. Судалгаа тооцоо хийгдээгүй нөгөө Хууль тогтоомжийн хуульд заасан шаардлага тандалт мандалд байхгүй тийм төсөл байна лээ. Тэр асуудлаар явцын дунд бас яриа гарах байх гэж би бодож байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс оруулсан. Дээд шүүхийн шүүгчдээс олон жил шүүн таслах ажил эрхэлсэн Батдэлгэр шүүгч, шүүгч байсан Зандраа гэх мэт энэ нь шүүхийн ажил амьдралд насаараа хутгалдсан ийм хүмүүсийг оролцуулсан. Шүүхэд бол яг одоогийн байдлаар ер бусын байдал бий болсон байгаа. Олон жил бол болж байгаа. Энэ шүүхийн хуулийг 4 салгаж Монголын нөхцөлд үл таарсан хууль батлуулсан нь шүүхийн ажилд маш их хүндрэл учруулж байгаа. Ганцхан жишээ дурдахад юуг Дээд шүүхийн танхимын шүүгч нар зөвхөн тухайн харьяалагдах танхимынхаа шүүх хуралд оролцоно, бусад танхимын шүүгч нар Дээд шүүхийн өөр танхимын хуралдаанд оролцож болохгүй гэсэн хуулийн хязгаарлалтыг 2012 оны хуулиар хийгээд хаячихсан. Энэнээс болоод одоогийн байдлаар саяхны байдлаар зөвхөн Дээд шүүхийн иргэний танхим дээр бүрэлдэхүүнгүй гэдэг шалтгаанаар 1100 хэрэг шийдвэрлэж шийдвэрлэгдэж чадахгүй бөөгнөрчихсөн байж байгаа.

Энэ хуулийн зорилт болбол энэ шүүхэд бий болсон ийм адармаатай адал балмад явдлыг таслан зогсоож, шүүхийг хэвийн ажиллах нөхцөлөөр хангах ийм л зорилготой юм. Анхан шатны шүүхийг эрүү иргэний гээд ялгаад хаячихсанаас шал шалтгаалаад 170-аад ерөнхий шүүгчтэй, 170 байсан байхаа. 170-аад ерөнхий

шүүгчтэй 500 шүүгч шүүгчийн дунд. Ийм сонин юм хийгээд хаячихсан. Энэ нь нарийн ярих юм болбол Үндсэн хуулийн зөрчилтэй холбоотой асуудал юм байгаа юм.

1992 онд Үндсэн хууль баталж байхад би Хууль зүйн тэргэнд дэд сайд байсан. Сайдаар Амарсанаа ажиллаж байсан. Яг шүүх эрх мэдлийн хэсгийг нь гардаж бичсэн хүн нь Амарсанаа сайд байсан. Тэр үед энэ ердийн буюу эрүү иргэний шүүхийг салгаж тусад нь бие даасан шүүх болгох тухай асуудал огт яригдаж байгаагүй. Эрүүгийн хэрэг дотроос салгаж хүүхдийн юм уу, насанд хүрээгүй хүүхдийн юм уу шүүх байгуулдаг барууны орнуудын туршлага байдаг тухай яригдаж байсан. Гэр бүлийн иргэний эрх зүйн харилцааны хүрээнд гэр бүлийн шүүх гэх мэтийн тийм шүүх байгуулах тухай татварын ч гэдэг юм уу ийм асуудал яригдаж байсан болохоос биш Монголын энэ уламжлалт ердийн шүүхийг хоёр салгах тухай асуудал огт яригдаж байгаагүй юм гэдгийг би бас энэ Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд тэр үед Үндсэн хуулийн асуудал хэлэлцэхэд оролцоогүй гишүүд байгаа учраас зориуд тэмдэглэж хэлэх ёстой гэж бодож байна.

92 оны Үндсэн хуулийг батлах үед шүүх эрх мэдлийн хэсгийг нь бага хурлаас томьёолоод Их Хуралд оруулахад Бага хурал дээр хэлэлцэж байхад ч гэсэн цэргийн шүүх прокурор байна, байхгүй гэсэн нэг л маргаан явагдсан. Бусад асуудлаар ямар ч маргаан явагдалгүйгээр ингээд тэр хэлэлцүүлэг дууссан түүхтэй юм байгаа юм. Энэ бүхнийг харгалзаж үзэж энэ саяын төслийг оруулж байна. Ер нь байдлаас ажиглаад байхад болбол энэ шүүх гэдэг юм болбол нэгдмэл байх зарчим нь алдагдсан. Нэгдмэл байх зарчим нь алдагдаад ирэхлээр шүүх ямар нэгэн байдлаар эмх замбараагүй байдалд ордог. Шүүхийн ерөнхий зөвлөлийн тухайд гэхэд 92 оноос хойш 3, 4 хувилбараар энэ удирдлагад ажиллаж ирсэн ийм түүхтэй.

92 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргаар Хууль зүйн сайд ажиллаж байхаар хууль батлаад 94 онд. 94 онд юм байна. Тэгээд тэрнээс хойш 2002 он хүртэл Хууль зүйн сайд нь Шүүхийн ерөнхий зөвлөлийг толгойлж байсан. Би 2000-аас 2002 оны хооронд 9 хүнтэй энэ ажлыг залгуулж байсан. Тэрний дараа Дээд шүүхийн ерөнхий шүүгч Ерөнхий зөвлөлийг толгойлдог хувилбар явсан. Энэ юмаар бараг 10-аад жил яваад, 12 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийг нь Дээд шүүхээс салгаад Шүүхийн захиргааны хууль гэдэг хууль баталж өгөөд ингээд энэ Ерөнхий зөвлөл тусдаа гарсан. Ийм 3 хэлбэрээр өнөөдрийг хүртэл үйл ажиллагаа явуулсан. Энийг би бас гишүүдэд нэг танилцуулчихъя гэж бодсон юм. Асуудал шүүхэд болбол хүндэрсэн. Би 81 оноос хойш яг шүүн таслах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн прокурор ажиллаж эхэлснээс хойш 40-өөд жил энэ шүүхийн ажилтай ямар нэгэн байдлаар ил далдуур прокурорын хувьд ч, сайдын хувьд ч, Ерөнхий зөвлөлийн даргын хувьд ч Их Хурлын гишүүний хувьд ч оролцсон байх юм.

7 Ерөнхий шүүгчийн нүүр үзсэн байх юм. Энэнээс 12 оноос хойш манай шүүхийн систем бүтэн завхарсан. Би энийг олон удаа хэлсэн. Миний хэлсэн ба үнэн

байсан үнэн байсан. Худлаа гэж хэлэх шүүгч, хуульч нэг ч гарахгүй байгаа. Одоогийн энэ оруулж байгаа төсөл бол бол энэ алдаа завхралыг таслан зогсоож 92 оны Үндсэн хууль сая батлагдсан нэмэлтийн хүрээнд шүүхийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлье гэсэн ийм л зорилготой хууль шүү гэдэг дээр хэлье.

Эцэст нь Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын дээд шүүх, Хууль зүй дотоод хэргийн яам энэ оруулж ирсэн төсөл дээр санал нэгтэй байгаа. Яг санал нэгдсэн төсөл оруулж ирсэн гэдгийг та бүхэнд танилцуулъя.

Х.Нямбаатар: Танилцуулга хийгдлээ. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Элбэгсайхан Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд, байна уу? Нөгөө танхимд байна уу? Цогт Улсын дээд шүүхийн эрүүгийн танхимын тэргүүн шүүгч. Зандраа Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн ажлын албаны зөвлөх. Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга. Атарцэцэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн. Сайнхишиг Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн захиргаа удирдлагын газрын дарга, байна уу? Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн. Энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Батбаяр яагаад ирээгүй байна вэ? Үнэнбатаа энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг яг цаашид энэ чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэхийг шийдэхэд бас орох ёстой шүү дээ. Нямдорж сайдын микрофоныг өгье.

Ц.Нямдорж: Ер нь Батбаярыг оролцуулах тухай санал тавьдаг нь зөв. Тэрнээс гадна Дээд шүүхийн ерөнхий шүүгчийг оролцуулах хэрэгтэй. Энэ Байнгын хороодын хуралдаан дээр дээд шүүхийн ерөнхий шүүгч прокурор ирэхлээр бие даасан хараат байдал нь алдагдчих юм шиг яриад л тойрч зугтацгаагаад байдаг юм бид нар. Их Хурал та нарын бие даасан хараат бус байдлыг чинь булааж авахгүй ээ. Амьдралыг чинь зохицуул зохицуулсан хууль батлах гэж байна. Тийм учраас тэр дарга нараа ирүүл. Энд шүүн таслах ажиллагааны асуудал ярихгүй. Шүүхийн талаар бий болсон бодит зовлонг та нар Их Хурал дээр танилцуулж байж асуудлаа шийдвэрлүүлэх ёстой. Ажлын хэсэг нь байлгүй яах вэ. Тэр 2 гол хүнээ ирүүлсэн нь дээр. Байнгын хорооны хуралдаандаа ч ирүүлэх ёстой, чуулган дээр ч ирүүлэх ёстой. Тэд нарын үгийг авч байж шийдвэрээ гаргах хэрэгтэй. Энэ бие даасан байдал гэдэг юм аа наанатай цаанатай ойлгож сурах хэрэгтэй. Энэ тогоондоо.

Х.Нямбаатар: Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийг бас ирүүлэх хэрэгтэй. Цогт шүүгч бас энийг анхаарна биз. Энэ бол Үндсэн хууль бид нар одоо батлаад хамгийн анхны органик хууль Шүүхийн тухай хуулийг бид нар хэлэлцэж эхлэх гэж байна шүү дээ. Бусад хуулиуд өнөөдөр хэлэлцэх эсэхийг нь шийдэхээр орж ирээгүй байгаа. Хамгийн эхнийх нь. 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд орсон өөрчлөлтийн хүрээнд шүүхийн, шүүх эрх мэдлийн бүлэгт гурван том өөрчлөлт орсон. Нэг нь тойргийн зарчмаар шүүх байгуулах тухай асуудал яригдаж байгаа. Хоёр дахь

нь болохоор хуульчдаас шүүгчдийг сонгон шалгаруулдаг шүүхийн захиргааны байгууллага буюу Шүүхийн ерөнхий зөвлөлийг бид нар бас сонгодог утгаар нь байгуулах энэ зарчмыг энэ хуулийн төсөлд тусгасан гэж ойлгож байгаа. Дараагийн дугаарт алдаа дутагдал гаргасан шүүгч нарт хариуцлага хүлээлгэдэг шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлж, шүүгчийн бүрэн эрхийг дуусгавар болгох энэ саналыг оруулдаг Шүүхийн сахилгын хороо гэдэг байгууллагыг бие даасан байдлаар байгуулахаар ингээд орж ирж байгаа.

Тэгээд энэ дээр нь кодификаци хийгдсэн тухай сая Хууль зүйн яамны сайд бид бүхэнд хэлж байна. 2012 он шүүхийн багц хуулийн хүрээнд 4 том хууль шүүхийн шүүхтэй холбоотой харилцааг зохицуулж байсныг бас сүүлийн үед ер нь Хууль зүйн яамнаас барьж байгаа бодлого бол салбарын харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжуудыг төрөлжүүлэн нэгдэх байдлаар зохицуулъя. Хууль тогтоомжийн зөрчил гарах нь багасна гэдэг агуулгаар энэ Шүүхийн тухай хуулийг нэгд төрөлжүүлэн нэгтгэсэн байдлаар өнөөдөр төслийг Хууль зүйн байнгын хорооны гишүүдэд танилцууллаа. Тэгээд өнөөдөр бол бид хэлэлцэх эсэхийг нь шийдээд явах ёстой яаралтай энэ хууль маань бас 5 дугаар сарын 15-наас эхэлж Үндсэн хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ. Хэдийгээр дагаж мөрдөх журмын хуулиар тухайн харилцааг зохицуулж байгаа хууль нь шинээр батлагдаагүй бол өмнөх одоо харилцааг зохицуулж байсан хуулийг хуулиар зохицуулах боломжийг нээж өгсөн гэлээ ч гэсэн бид нар энийг яаралтай хэлэлцэж батлах ёстой гэж бодож байна.

Энэ хэлэлцэх эсэхийг шийдсэний дараа бас ажлын хэсэг байгуулагдах байх. Ажлын хэсэгт Их Хурлын даргад бас оролцохоо илэрхийлсэн өөр Байнгын хороодод харьяалагддаг гишүүд бас саналуудаа ирүүлсэн байгаа. Тэгээд энэ болгоныг харгалзаж үзээд Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсгийг байгуулаад яаралтай ажилд нь оруулах байх. Би Хууль зүйн байнгын хорооны даргын хувьд бас энэ шүүхийн хуулийн төсөлд хэд хэдэн саналууд өгсөн тэрийг бас ажлын хэсэг дээр ярилцсан. 17 зүйлийн саналыг бас ажлын хэсэгт хүргүүлсэн байгаа. Зарим нь туссан, зарим нь тусаагүй явж байгаа. Тэгээд бид нар бол аль нэг одоо улс төрчөөс, Ерөнхийлөгчөөс хамааралгүй хараат бус ийм шүүхийн тогтолцоог л бүрдүүлэхийг энэ сүүлийн хэдэн жил зорьсон гэдгийг бас сая Хууль зүйн сайдын танилцуулгад дурдагдаж байх шиг байна.

Тэгээд хэлэлцэх асуудлынхаа дарааллын дагуу хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуух асуулттай гишүүд байвал нэрсээ өгье. Раднаасэд гишүүнээр тасаллаа. Батнасан гишүүн.

О.Батнасан: Хэлэлцэх эсэхийг бол дэмжиж байгаа. Манай Хууль зүйн сайд Байнгын хорооны дарга хоёр ч бараг хичээл заачихлаа л даа. Бараг ч асуухыг үлдсэнгүй л дээ. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр бид 5 заалт оруулах гэж нэлээд ажилласан юм. 3 заалт нь орсон. Тэр гурван заалтын хүрээнд шинэчилсэн найруулга

Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн орж ирж байгаа байх. Зүгээр шүүхийн бие даасан байдал хараат бус байдлыг шүүгчийн хараат бус байдлыг хангах талаар одоо хангалттай зүйл орж ирсэн байх гэж бодож байна. Шүүгчийн чинь ёс зүй ямар байгаа билээ өнөөдөр. За яах вэ бие даасан байдлаа хангуулаад авчихдаг юм байж, хараат бус байдлаа хангуулаад авчихдаг юм байж. Ерөнхийлөгч саналаа өгсөн гэж байна энэ бол маш сайн. Яагаад гэхээр тэр институтээс бие даасан байдлыг чинь хангах институт руу шилжиж байгаа.

Хоёрдугаарт олон өөрчлөлт орсон байна. Тэр эрүүгийн танхим, иргэний танхим, захиргааны танхимынхан бол бас шүүн таслах ажиллагаанд оролцож болохоор заалтууд орсон байна. Зүгээр нэлээн дэвшилттэй заалтууд бол орсон байна. Энэ шийдэгдэхгүй байгаа хүний хууль хууль ёсны эрхийг зөрчигдөөд байгаа хэргүүдийг ер нь хэзээ шийдэх вэ? Одоо зөндөө хэрэг бараг 1000 гаруй хэрэг хүлээгдсэн байгаа гэж байна шүү дээ. Энэ тал дээр ямар ажил явуулж байна вэ?

Хоёрдугаар асуудал энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үед яригдаж байсан Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл хоёрын уялдаа холбоог яаж зохицуулсан бэ? Энэ бас одоо нэлээн яригдаж байгаад үлдсэн зүйл. Дараагийн асуудал бол тэр 2012 оны шүүхийн хууль 2015 оны шүүхийн хуулийг л одоо энэ л буруу болчихлоо гэж бухаад зүхээд байдаг. Яг энэ алдаа чинь засагдаж байгаа юм уу одоо. Энэ хуулиар Улсын дээд шүүхийнхэн буюу одоо шүүхийн системийнхэн шүүгч нар үг ямар ч асуудалгүй асуудлыг бид шийдэж байгаа гэдэг ийм тайлбарыг өгч чадах уу?

Шүүхийн хуультай холбоотойгоор Эрүүгийн хуультай холбоотойгоор асуудал тавихад шүүхийн Улсын дээд шүүхийнхэн ирдэггүй шүү дээ. Ганц хүн явуулчхаад л тэгээд л бидний одоо хараат бус байдалд битгий нөлөөлөөд ухаан юм яриад суудаг шүү дээ. Үнэн шүү дээ Цогтоо, хараад байх юм байхгүй наашаа. Тэгээд энэ хууль дээр яг та нар одоо бүрэн бүрэлдэхүүнээрээ санал зөрөлдөхгүй яг концепц санаа бодлоо оруулж чадсан уу? Ийм зүйлийг асууя.

Х.Нямбаатар: Хариулъя. Батнасан гишүүн бас энэ нэг чуулганы Байнгын хорооны хуралдаан дээр хэдүүлээ бас бие биедээ хүндэтгэлтэй хандана. Бид нар ямар ч хичээл та бүхэнд заагаагүй шүү дээ. Энэ чуулганы завсарлагаагаар ямар асуудлууд болсон, саналууд хаашаа хүргүүлсэн, тэр саналууд ямар байдлаар тусаад явж байгааг л ярьж байгаа шүү дээ. Хариулт өгье. Батнасан гишүүний асуултад Цогт гишүүн хариулъя. Индрийн микрофон.

Б.Цогт: Та бүхний энэ өглөөний амар амгаланг айлтгая. Батнасан гишүүний асуулт гол асуулт маань энэ иргэний танхимын үйл ажиллагаа маань доголдсон байгаа энийг яаж шийтгэж байгаа гэж асууж байх шиг байна. Ерөнхийлөгч зарлиг гаргаж түдгэлзүүлсэн иргэний танхимын хоёр шүүгчийн бүрэн эрхийг буцааж

сэргээсэн байгаа. Энэ сарын өмнө. Тэгээд одоо иргэний танхим бол хэвийн нөхцөлөөр ажиллаж байгаа. Ачаалал болбол үнэхээр түрүүн Хууль зүйн сайдын хэлсэн тэр 1000 гаруй хэргээр хуримтлагдсан нь үнэн. 8 танхим 8 шүүгчтэй байсан. Тэрний 5 шүүгчийн бүрэн эрх тодорхой хугацаанд түдгэлзээд ингээд 2 шүүгчийн бүрэн эрхийг сэргэж одоо 5 шүүгчтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа.

Энэ хуулийн төсөл дээр бол анхнаасаа Улсын дээд шүүх бол Ерөнхий зөвлөл хамтран ажилласан. Энэ дээр бол аль алиных нь санал бол бүрэн хэмжээгээр тусгагдсан. Бид нарын хооронд хоёр байгууллагын хооронд одоо энэ дээр саналын зөрүүтэй асуудал байхгүй ээ. 2015 оны хуулиас болж зарим зүйлүүд бол эрс өөрчлөгдөж энэ болбол шүүгч нарын одоо хүсэн хүлээсэн хууль төсөл болж чадсан гэдэгт бол Улсын дээд шүүх ийм бодолтой байгаа.

Х.Нямбаатар: Нэмж тодруулах уу Батнасан гишүүн? Та чинь өнөөдөр юу болчихсон юм бэ? Та чинь л одоо энэ ийм хурлыг хэрүүлийн шинж чанартай, хэрүүлийн чанар чанартай зохион байгуулаад байх юм. Дараагийн Раднаасэд гишүүн. Та дараа нь нэр өгч болно. Раднаасэд гишүүн нэр өгсөн байсан. Дараа нь Батзандан гишүүний нэрийг оруулъя.

Ш.Раднаасэд: Өмнөх яг Шүүхийн тухай хуулиас яах вэ дээ Шүүхийн захиргааны хуулиа нийлүүлээд нэгтгээд ингээд иж бүрэн нэг цогц зүйл болгочихсон байх шиг байна. Тэгэхээр энэ нь ч бараг зөв байх. Шүүхийн ерөнхий зөвлөл гээд нэг тусдаа, Дээд шүүх, шүүх гээд тусдаа ингээд нэг хоорондоо байлдах аястай явдаг. Тэгээд хаана юу болоод байгаа нь мэдэгдэхгүй энэ ийм зовлонтой юм байсан. Дэвшилттэй зүйлүүд байх шиг байна. Зарим нэг зүйлүүдийг дахиад хэлэлцэх эсэх асуудал явах үеэр нэг, хоёрдугаар хэлэлцүүлгийн үеэр би бас саналуудаа гаргая гэж бодож байна. Одоо нэг асуух зүйл байна. Одоо энэ шүүхийн яг ерөнхий зургаар нь харахад Зандраа шүүгчээ миний харж байгаагаар Шүүгчдийн зөвлөл гэдэг чинь Ерөнхий зөвлөлийнхөө дээр, Сахилгын хорооныхоо дээр, Мэргэжлийн хорооныхоо дээр ийм нэг шинэ бүтцэд бий болчихлоо тийм үү?

Шүүгчдийн зөвлөл зөвхөн шүүгчдээс бүрдсэн. Энэ хэдэн хүн байгаа юм. Сая болбол нэг ийм пропорциональчилсан маягаар биччихсэн байна. Нэгдүгээрт энэ тоо хармаар байна. Энэ хэр зөв бэ? Шүүхийн ерөнхий зөвлөлийн 50 хувь шүүгчдийн зөвлөлөөс очно. Өөрөөр хэлбэл 10 хүний 5 нь. Энэ болбол хангалттай Шүүхийн ерөнхий зөвлөлөө ч байгуулаад, даргаа ч томилох, сахилгын хорооны 9 гишүүний 4 нь шүүгчдийн зөвлөлөөс очно. Энэ бол ялгаагүй сахилгын зөвлөлийн үйл ажиллагаа шууд явах. За мэргэжлийн хороог чинь би сая хараад сууж байлаа. Бас л энэ мэдээж дотроосоо байна. Тэгэхээр энийг яг яаж харж зурж хийсэн бэ? Одоо шүүгчдийн зөвлөл гэдэг чинь ерөнхийдөө явж, явж ерөнхий шүүгчийн атганд энэ шүүхийн систем чинь өөрөө дангаараа орчих ийм аюул байна уу,

Миний харж байгаа яг ингээд хүснэгтлээд гэдэг юм уу, одоо зураг хэлбэрээр болгоод харахад. Энийг нэгдүгээрт тодруулмаар байна. Энэ нэг талдаа эсхүл зөв, эсвэл туйлын буруу ийм л юм руу явна. За байз би дуусгая.

Хоёр дахь асуулт. Шүүхийн ерөнхий зөвлөл 4 жилээр байна гэдэг энэ зөв үү? Энийг бас тооцож үзэх ёстой. Энийг улс төрийн сонгуулийн ялангуяа Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн сонгуулийн циклээс бүр зөрүүлж орхимоор байгаа юм. 6 байх юм уу, өөр хэд байдаг юм. Эсхүл 3 байх юм уу. Үндсэн хууль дээр 4 гэж байгаа бил үү? Хугацаа тавиагүй гэж санагдах юм. Тийм бол тийм байгаа байх. Нэг одоо шүүхүүд дээр хэрэгждэггүй нэг хэд хэдэн зүйлүүд байдаг. Энэ мэргэжлийн хороо чинь ажиллахгүйгээс болж чадваргүй шүүгчид үйл ажиллагаа явагддаг. Энэ хэрээрээ буруу шийдвэрүүд гардаг. Шүүх дээр нэгэнт шийдсэн асуудлаар дахиад яг ижил түвшний захиргааны хэргийн шүүх дээр нь Улсын дээд шүүхийн шийдвэр гарчхаад байхад захиргааны хэргийн шүүх дээр дахиад хэрэг үүсгэсэн ингээд шалгаад явж байна гэдэг өргөдөл гомдол хүртэл ирдэг байсан. Хууль зүйн байнгын хороон дээр байхад. Энэ чинь ерөөсөө мэргэжлийн алдаа байгаа байхгүй юу. Сонирхол, мэргэжлийн алдаа хоёр нийлэхээр ийм байдал руу явчхаж байгаа юм.

Энэ мэргэжлийн хорооныхоо үйл ажиллагааг чанаржуулах энийг гомдол мэдээллийг нь түргэн болгодог, ил тод болгодог, нээлттэй болгодог ялангуяа энэ мэргэжлийн хороотой холбоотой биш. Ер нь шүүхийн шийдвэртэй холбоотой шүүхийн шийдвэрийг ил тод нээлттэй болгох чиглэл ямар одоо зохицуулалтууд орсон юм бэ? 3 дахь юм. Одоо энэ шүүгч нар дээр тавигдах шалгуур гээд байгаа. Энэ өөрчлөгдөж байгаа байх тийм үү? Одоо ... /минут дуусав/

Х.Нямбаатар: Раднаасэд гишүүн нэмэлт 1 минут өгье.

Ш.Раднаасэд: Энэ хууль батлагдсантай холбогдуулаад одоо шүүгчээр ажиллаж байгаа хүмүүс дээр дахиад сонгон шалгаруулалт явуул гэх юм уу, тийм аттестатчилал явуулах ийм орчин, эрх зүйн орчин бүрдэх үү? Өөрөөр хэлэх юм бол шалгуур нөхцөл байдал хөдөлсөн өөрчлөгдсөн эсхүл ерөөсөө энэ шүүхийн системд байгаа буруу, зөрүү юмаа бид нар өнгөрсөн 3, 4 жил л ярилаа. Одоо энийгээ засаж залруулъя ч гэдэг юм уу, тийм зүйл байна уу?

3, 4 дэх нэг зүйл энийг бид нар энэ хууль дээр санал хэл санал хэлэхдээ ч би хэлье дээ. Оруулж ирэх ёстой. Ерөөсөө энэ шүүхийн тогтвортой байдал өөрөө шүүгчийн тогтвортой байдал чинь өөрөө шүүх нь зөв буруу байх уу гэдгийг хангаж байгаа ганц баталгаа нь юм аа. Тэгэхээр энэ хууль руу хамаагүй гар хүрээд байдаг, ороод байдаг хэн нэгэн хүн нь очоод Шүүхийн тухай хуулийг дур зоргоороо ороод маажаад хөдөлгөөд байдаг ийм юмыг л одоо болиулмаар байна. Өмнөх Ерөнхийлөгчийн хувьд Шүүхийн захиргааны хууль гэдэг ... /минут дуусав/

Х.Нямбаатар: Зандраа шүүгч тэр индрийн микрофон дээр очоод хариулъя. Болох юм уу, суудал дээрээсээ болох юм байна. Болохгүй юм байна. Индрийн микрофон гэж байна.

О.Зандраа: Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Ингээд Раднаасэд гишүүний асуусан 4 асуултад хариулъя. Нэг дэх асуудал Шүүгчдийн зөвлөл гэдэг өөрөө удирдах ёсны байгууллага шинээр Монгол Улсын Шүүхийн хуулийн шинэчилсэн найруулга дотор орж ирсэн байгаа. Энийг бол бид бас ардчилалтай бас олонхыг хүндэтгэсэн ил тод байдлыг бий болгосон ач холбогдолтой заалт гэж ингэж ойлгож байгаа. Яагаад ач холбогдолтой гэж үзэж байгаа вэ гэхээр энэ шүүгчдийн зөвлөл гэдэг маань анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн олонх өнөөдөр давж заалдах шатны шүүхэд 109 шүүгч, анхан шатны шүүхэд 370 шүүгч, Улсын дээд шүүхэд 25 шүүгч ажиллахаар байгаа. Тэгэхлээр Улсын дээд шүүхийн нийт бүрэлдэхүүнээрээ анхан болон давж заалдах шатны шүүхийн дээр дурдсан шүүгчдийн 51-ийн ирцтэйгээр асуудлыг дийлэнх олонхын саналаар шийдэхээр энэ Шүүгчдийн зөвлөл гэдэг нэр томъёо орж ирсэн байгаа. Шүүгчдийн зөвлөлийн цаашдын ач холбогдлыг бид өндрөөр харж байгаа. Анхнаасаа Хууль зүйн яамнаас оруулж ирсэн төслөөр бол нийт шүүгчдээс өнөөдөр ажиллаж байгаа одоо 504 шүүгчийн бүрэлдэхүүнтэй Шүүгчдийн зөвлөл ажиллана гэсэн ийм төсөл орж ирсэн. Энэ төслийг Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын дээд шүүхийн ажлын хэсэг дээр ярьж байгаад хөрөнгө мөнгөний асуудал, эдийн засгийн байдлаа харгалзаж үзээд ерөөсөө 51 байхад бол хангалттай юм байна. Өнөөдөр Монгол Улсад шүүн таслах үйл ажиллагаа эрхэлж байгаа эрүү, иргэн, захиргааны нийт шүүгчдийн 51 буюу ердийн олонхын ирцтэйгээр энэ асуудлыг шийдээд явах нь бол ач холбогдолтой юм аа гэж ингэж үзсэн юм.

Яагаад гэхлээр урьд нь Шүүхийн ерөнхий зөвлөл, Мэргэжлийн хороо, Сахилгын хорооны гишүүдийг бол дандаа хязгаарлагдмал бүрэлдэхүүнийг сонгож байсан. Хуульчдын холбоо, бүх шатны шүүхийн зөвлөлийг сонгож байсан. Тэгэхлээр энийг бол маш өргөн хүрээнд авч үзэж байгаа юм. Одоо өнөөдрийн байдлаар бол. Энэ шүүгчдийн зөвлөл ажиллаад эхлэх юм бол одоо шүүгчдийн зөвлөлөөс Шүүхийн ерөнхий зөвлөлд сонгогдож ажиллах 5 шүүгчийг шүүгч дотроосоо нэр дэвшүүлж Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээ сонгодог болно. Мөн мэргэжлийн хороо, сахилгын хороо тус тусын тоонд нь багтааж Шүүгчдийн зөвлөл энэ асуудлыг шийдэж болж байгаа. Энүүгээрээ бас нэлээн ардчилалтай болж байгаа юм болов уу, олонхыг хүндэтгэсэн ийм юм болж байгаа юм болов уу гэж ингэж ойлгож байгаа учраас энэ бол тийм бас буруу жишиг тогтоогоод явж байгаа юм байхгүй. 2002 оны Шүүхийн тухай хуульд шүүгчдийн зөвлөл гэж байсан. Энэ шүүгчдийн зөвлөлийн хийж гүйцэтгэдэг үйл үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг анхан болон давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч нар хэрэгжүүлж ирсэн.

Энэ дээр бол бас Ерөнхий шүүгч нар нэгэнт одоо Ерөнхийлөгчөөс томилогддог байсан үе учраас шүүгчдийг төлөөлөх бүрэн эрхтэй юу гэдэг асуудал яригдаж байсан. 1993 оноос ерөнхий шүүгч нар томилогдож эхэлсэн. 2002 оны хуулиар шүүгчдийн зөвлөлд ерөнхий шүүгч нар орж ажилладаг байсан. Тэгээд энийг бол бас өргөжүүлсэн. Шүүгчдийн ер нь шүүгч нарт өөрсдийнх нь өөрөө удирдах ёсны чиг үүргээ хэрэгжүүлж байгаа байгууллагуудын бүтцэд орж ажиллах хүмүүсийг өөрсдөө сонгох нь илүү ач холбогдолтой юм байна гэдэг дээр санал нэгдсэн. Нэг дэх асуудал.

Мэргэжлийн хорооны асуудал байгаа юм. Мэргэжлийн хорооны асуудал бас Раднаасэд гишүүний ярьж байгаатай адил бас зарим зүйлээр доголдож байсан юм байгаа. Гэхдээ одоо Мэргэжлийн хороо бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж байгаа. Одоо яг а анхан болон давж заалдах шатны шүүхийн сул орон тоо мөн шүүхийн ерөнхий шүүгч нарын сонгон шалгаруулалт одоо явж байна. Онцгой байдлын газартай яриад ингээд дэгийг нь хангаад тэр онцгой байдалд яаж ажиллах ёстой юм. Энэ дэг журмынхаа дагуу шалгалтын үйл ажиллагаа явж байгаа. Ер нь ерөнхий зөвлөлийн гишүүдийг бол урьд нь би түрүүн хэлсэн хязгаарлагдмал одоо нэг байгууллагаас юм уу, олон нийтийн байгууллагаас ингээд хүн сонгоод байдаг байсан. Энэ одоо зөвлөл шүүгчдийн зөвлөлөөс бол сонгогдож байгаа.

Гэхдээ мэргэжлийн хорооны хариуцлага бол улам хүндэрч байна. Яагаад гэхлээр хуульчдаас шүүгчдийг шилж олох чиг үүргийг ерөнхий зөвлөлийн байгуулсан мэргэжлийн хороо хэрэгжүүлж байгаа. Энэ мэргэжлийн хороон дээр одоо шүүгчийн хариуцлага, сахилга гэж түрүүн яригдаад байна. Ёс зүйн асуудал яригдаад байна. Энэ дээр бид нар бас анхааралтай хандахгүй бол болохгүй байгаа. Ер нь болбол шүүгчийн хараат бус байдаг гэдэг бол өөрөө шүүн таслах үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд л хэрэглэгддэг юм шүү дээ. Бусад үед одоо өөрийгөө тэр хараат бус байдал гэдгээр одоо халхавчлах юм уу, ийм байдлаар асуудалд хандаж болохгүй юм байгаа юм. Тэгэхлээр шүүгчдийн сахилга хариуцлагыг сайжруулах тал дээр бол ерөнхий зөвлөл, Дээд шүүх бол ярьж хэд хэдэн асуудал дээр энэ зарчмын шийдлүүдийг хийсэн байгаа. Энэний нэг том шийдэл нь ерөөсөө анхан шатан дээр хэрэг маргаан хянан шийдвэрлэж байгаа шүүгч өөрөө хуулийг удаа дараа зөрчдөг, ноцтой зөрчил гаргадаг хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчдөг ... минут дуусав.

Х.Нямбаатар: Хариулт болсон уу? Нөгөө дэгээрээ явж байгаа. Тийм үү, за нэмээд хариулт индрийн микрофоныг өгье. Энэ юуныхаа хурал зохион байгуулахын энэ индрийн микрофон дээр 4 минутын тохиргоо юу өгөх хэрэгтэй байх шиг байна. Та микрофоноо шалга даа.

О.Зандраа: Тэгэхлээр одоо энэ хууль хэрвээ 2020 оны 5 сарын 25-наас дагаж мөрдөөд эхлэх юм бол одоо энэ мэргэжлийн хороонд энэ шүүн таслах үйл

ажиллагаанд хариуцлагагүй хандаж байгаа, хууль хэрэгжүүлэхэд буруу тайлбарлаж хэрэглэдэг ийм шүүгч нартай бол тодорхой хэмжээний хариуцлага тооцох ийм заалт орж ирж байгаа. Тэгэхлээр энүүгээрээ бас мэргэжлийн хороо бол бас бүрэлдэхүүнийг сайжруулах зайлшгүй шаардлага гарч ирж байгаа учраас мэргэжлийн хороо 4 жилийн хугацаатай ажиллана. Мэргэжлийн хорооны бүрэлдэхүүнд 9 гишүүн байна. Энэний зургаа нь 5-аас дээш жилээр ажилласан давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шүүгч байна гэж ингэж бүрэлдэхүүнийг зааж өгснөөрөө бол энэ бүрэлдэхүүн цаашид энэ чиг үүргээ хэрэгжүүлээд өгөх бүрэн боломж нээгдэнэ гэж ингэж ойлгож байгаа. Шүүгчдэд тавигдах шалгуур үзүүлэлтүүд бол энэ хуульд бол нэмж орж ирсэн. Хуульчдаас шүүгчдийг шилж олгох шалгуур болзол шаардлага бол нэмэгдсэн. Дээр нь одоо шүүн таслах үйл ажиллагаа эрхлэх эрхтэй байж байгаа шүүгч нарт хориглолт буюу хязгаарлалт нэмэгдэж орно.

Х.Нямбаатар: Одоо та тэгээрээ нэмэлт 1 минут тодруулчихсан. Тэгээд сая Раднаасэд, байгаа билүү? Раднаасэд гишүүний 1 минут.

Ш.Раднаасэд: Асуусан асуултаа тэгээд давтаад асуугаад байх уу? Энэ шалгуур хөдөлсөнтэй холбоотойгоор одоо шүүгч нар дотор хөдөлгөөн хийх үү гэдэг юм байгаа шүү дээ. Байж байгаарай Зандраа шүүгч протоколд наадах чинь үлдэх ёстой учраас. Хоёрдугаарт энэ шүүхийн шийд, би бас түрүүн та мэргэжлийн хорооны юутай мэргэжлийн хороогоо түлхүү явчихлаа. Энэ шүүхийн шийдвэрийн ил тод байдал, энэ шүүхийн үйл ажиллагааг ил тод болгох чиглэлээр энэ хууль дээр туссан ийм, ийм зүйлүүд дээр бид нар болбол бас ил тод нээлттэй болгох юм гээд. Одоо иргэдийн төлөөлөгч гээд л нөхөр байгаа тийм ээ. Шүүх хуралдаанд сууж байгаа. Тэр хүн болбол ямар ч үүрэг оролцоогүй шахуу байна гэж шүүмжлээд байгаа шүү дээ ерөөсөө. Бас нэг байнга гарч ирж байгаа. Шүүхийн үйл ажиллагааг ил тод болгож байх ёстой. Тэрэнд хараа хяналт одоо юу гэдэг юм зөв дэгийн дагуу явж байна уу, одоо нөгөө шүүгдэгчийн эрх ашиг одоо юу шүүгчийн өөрийнх нь оролцоо ямар байна ... /минут дуусав/

Х.Нямбаатар: Индэрийн микрофон. Зандраа шүүгч та яг нөгөө минуттай учраас маш товчхон хариулахгүй бол. Бид нар дэгээр явна шүү дээ.

О.Зандраа: За. Одоо ажиллаж байгаа шүүгч нарын хувьд бол эрх зүйн байдал хөндөгдөхгүй ээ. Энэ шинэ хууль гарснаар. Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу шүүхийг тойргийн журмаар байгуулах юм болбол шүүгчийг сэлгэн томилох өөр шүүхэд томилох тухай асуудал бол яригдана. Ер нь Ерөнхийлөгчийн бүрэн эрхтэй холбоотой асуудлыг Үндсэн хуулийн 33 дугаар зүйлд өөрчлөлт орсонтой холбогдуулаад хэд хэдэн зүйлийн бүрэн эрх нь бол сахилгын хороо, шүүхийн ерөнхий зөвлөлд шилжсэн байгаа. Болсон уу тийм ээ? Тэр шүүх хуралдаан нээлттэй байх явдал бол хуульд тусчихсан. Цахимаар явж байгаа. Нээлттэй байдлыг хангасан Засгийн газрын хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед бол шүүх

хуралдаануудыг ер нь олон нийтийн телевизээр явуулбал яасан юм бэ гэсэн ийм асуудал яригдсан. Энэтэй холбогдуулаад төслийн 16-ын, 13.6-д бол нэмэлт, өөрчлөлт орчихсон явж байгаа.

Х.Нямбаатар: Ажлын хэсэгт баярлалаа. Батзандан гишүүн.

Ж.Батзандан: Олон хууль хүчингүй болж байгаа. Шүүхийн ерөнхий зөвлөлийн тухай хууль хүчингүй болж байгаа, дагалдах маш олон хуулиудад нэмэлт, өөрчлөлт орж байгаа. Тэгээд бие даасан цогц нэг хуулийг ажлын хэсгээс Улсын Их Хурал руу оруулж ирж байна гэж би харж байна. Тэгээд энэ хуулиар тулгамдсан шүүх засаглалд тулгамдаад байгаа асуудлуудаа хэрхэн яаж шийдсэнийг бүгдээрээ илэн далангүй ярих хэрэгтэй байх. Шүүгч нар улс төрийн томилгоо, авлига хээл хахууль, бүлэглэлийн нөлөөнд ордог болоод удаж байгаа. Энэ томилгооны системийг яаж улс төрөөс холдуулсан юм бэ гэдгийг одоо илэн далангүй ярих ёстой. Энэ томилгоог чинь харахаар яг л урьдын адил улс төрийн байгууллагаас хараат байдлаар л зохицуулж өгсөн байна. Байнгын хорооноос тэдэн гишүүн гэж. Үгүй ээ Байнгын хорооны 3 гэдэг чинь бол эрх баригч намын 3 гэсэн үг. Байнгын хорооны даргын мэддэг 3 гэсэн үг биш. Энийгээ хэдүүл яг тодорхой болгомоор байгаа юм. Амьдрал дээр бууж. Одоо шүүгчдийн зөвлөл гэж нэг байгууллагыг та нар байгуулж оруулж ирсэн байна. Шүүгчдийн зөвлөлөөс 3 ч гэнэ үү. Янз бүрийн тоонууд тавьсан л байна л даа.

Шүүгчдийн зөвлөл гэдэг чинь шүүхийн ерөнхий, ерөнхий шүүгчийн 3 гэсэн үг амьдрал дээр. Тэгэхээр бид энэ нэг ийм өөрсдийгөө хуурсан өмнөх амьдралын практикт байсан муу уламжлалуудыг яаж засаж залруулах юм бэ гэдгээ илэн далангүй ярья. Монгол хүнийхээ онцлогт нийцсэн хууль хийе. Монгол хүн чинь их сонин шүү дээ. Шагнал өгсөн хүндээ үхэн үхтлээ үнэнч, өөрийг нь томилсон хүндээ үхтлээ үнэнч. Авлигал авчихвал авлига авсан нөхрийнхөө төлөө ард түмнээ мартаад гүйчихдэг ийм л шүүгч нарыг би олон жил харлаа. Тэр Салхитын мөнгөний орд дээр авлигал авсан нөхдүүдийг бид нэр устай нь харсан шүү дээ ямар хүмүүс байгааг.

Тэгэхээр энэ хуулиар бүлэглэлийн эсрэг тэмцэл шүүхийн хараат бус бие даасан байдлыг бий болгож жинхэнэ шүүхтэй болъё. Үнэн шүүхтэй болъё гэдэг асуудлыг л энэ хуулиар бид шийдэх ёстой юм. Энэ хуулийг оруулж ирж байгаа шалтгаан нь бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой гэдгийг бид нар ойлгож байгаа. Тэгэхээр манай шүүгч нар шүүхийн ерөнхий зөвлөл та нар ярьж байгаад нэг хууль оруулж ирж байгаа. Энэ бол та нар өөрсдийнхөө эрх мэдлийг баталгаажуулах гэж л юм хийж байгаа. Би бол энийг ойлгож байна. Ер нь засаглалын балансын онол гэж байдаг. Та бүхэн мэдэх байх. Гүйцэтгэх засаглал, хууль тогтоох засаглал, шүүх засаглалын хоорондын балансыг харилцан хяналтын системийг л зөв хийхгүй бол дарангуйлал тогтдог гэж үздэг. Ний нуугүй хэлэхэд өнөөдөр шүүхийн дарангуйлал тогтчихоод байгаа шүү дээ.

Шүүхийн ард байгаа шүүгч нарыг томилуулсан бүлэглэлийн дарангуйлал тогтчихсон шүү дээ. Шүүх дээр очоод том хэргүүд бүгд гацаанд орсон. Та нар дуртай хэргээ шийднэ, дургүй эргээ дарна. Эсвэл хөөн хэлэлцэх хугацаа гэж би худлаа юмаар хойшлуулна. Тэр эрүүдэн шүүсэн хэрэг мэргийг хэдэн жил та нар дарж байгааг бид нар бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Санаатайгаар дарж байгаа, бүр санаатайгаар. Танай ерөнхий шүүгч чинь оролцож дарж байгаа. Ийм л байгаа шүү дээ бодит амьдрал дээр. Тэгэхээр одоо энэ Шүүхийн тухай шинэ хууль батлах ... /минут дуусав/

Х.Нямбаатар: Батзандан гишүүнд 1 минут өгье.

Ж.Батзандан: Шүүхийн тухай шинэ хууль батлахдаа үзэл баримтлалыг нь өнөөдрөөс эхлээд ярилцаж эхэлж байна. Илэн далангүй ярьж Зандраа шүүгчээ. Тэр ерөнхий шүүгчээ ч авчир. Шүүхийн ерөнхий зөвлөлийнхөө даргыг ч авчир, өөрсдөдөө эрх мэдэл булааж авах гэж оролдож байгаа, өөрсдийнхөө эрх мэдэл, тав тух, ая тухыг, дархан эрхийг баталгаажуулах гэж хуулийн хулгай хийдэг байдлыг одоо зогсоох ёстой. Тэгэхээр мэдээж хэлэлцэхийг дэмжиж байна. Яагаад гэхээр Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж бид нар хэлэлцэх ёстой.

Гэхдээ шүүхийн дарангуйллыг, ерөнхий шүүгчийн дарангуйллыг, бүлэглэлийн дарангуйллыг шүүхээс яаж зайлуулах юм бэ? Энийгээ л хэдүүлээ ярьж. Тулгамдсан асуудал ийм 25 асуудал шүүх дээр тулгамдаж байгаа. Энэ 25 асуудлыг бид нар ингэж, ингэж шийдсэн гэдэг юмаа самбар дээр бичиж байгаад ярьж. Нэг Зөрчлийн хууль шиг юм байж болохгүй. 220 захиргааны зөрчлийг нийлүүлээд нэг хуульд ... /минут дуусав/

Х.Нямбаатар: Хариултаа авах уу? Хэн хариулах вэ? Индрийн микрофоныг өгчих. Өнөөдөр Байнгын хорооны 2 дахь хэлэлцэх асуудал бол Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнийг сонгон шалгаруулах журмыг батлах гэж байгаа юм. Тэгээд энэ журам дээр хамгийн анх удаагаа Байнгын хороо яаж нээлттэй сонгон шалгаруулалт явуулах вэ гэдэг журмыг бид нар энэ Шүүхийн тухай хуулиас өмнө хийгээд өнөөдөр зарлах гэж байгаа. Бүрэлдэхүүний нь. Тэгэхээр Батзандан гишүүн бас энэ журмыг манай ажлын юу Байнгын хорооныхон Батзандан гишүүн нөгөө журмыг өгөх хэрэгтэй байгаа. Тийм, энэ дээр бол Их Хурлын дарга, Байнгын хорооны дарга ерөөсөө нэр оруулахгүй. Олон нийтэд нээлттэй зарлаад маш тодорхой шалгууруудыг тавиад тэгээд байгууллага байгууллагын 9 байгууллагын төлөөлөлтэй комисс гараад тэгээд хүмүүсийг бүртгэж аваад, бүртгэж авсан хүмүүсээ сонгон шалгаруулалт хийгээд Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар нээлттэй хэлэлцүүлэг хийгээд эцэст нь тэндээсээ шалгарч үлдсэн хүмүүсийг чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж нийт гишүүдийн дийлэнх олонхын саналаар батлах, ийм одоо эхний оролдлого хараат бус байдлаар хэрхэн яаж одоо Байнгын хороо хүн нэр дэвшүүлж баталж болох вэ гэдгийг л бид хийхийг зорьж хичээж ажиллаж байгаа.

Тэгээд одоо энэ ажлын хэсгийн бүрэлдэхүүнд бас нам намын төлөөллүүд энэ шүүхийн тухай хуулийг хэлэлцэхэд орох ёстой. Батзандан гишүүн бас та намын даргын хувиар ороорой гэж бодож байна. Индрийн микрофоныг өгье. Хууль зүй, дотоод хэргийн яам Сайнзориг.

П.Сайнзориг: Батзандан гишүүний асуултад хариулъя. Хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаад бас талархал илэрхийлж байна. Ер нь нөгөө шүүхийн зөвлөлтэй холбоотой бас асуудлууд яригдаад байх шиг байна. Яг энэ бол үндсэндээ Үндсэн хуулийн үзэл санаатай бас бид хэд уялдуулж бичсэн байгаа. 49.5 дугаар зүйл дээр шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг 5-ыг шүүгч нар дотроосоо сонгоно гэж одоо орсон байж байгаа. Саяын өөрчлөлтөөр. Тэгэхээр ерөнхий шүүгч нарын зөвлөлөөс биш. Тодорхой нэг ийм нэг хэсэг бүлэг ч гэдэг юм уу олон нийтийн байгууллагаас биш гэж ерөөсөө энэ дээр Үндсэн хуулийн агуулгаар бичигдээгүй.

Өөрөөр хэлэх юм бол Монгол Улсад Ерөнхийлөгчийн зарлигаар томилогдон ажиллаж бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа шүүгч нар дотроосоо сонгох энэ үзэл санаа орсон. Тэгэхээр энийг бид хэд бас хуулийн төсөл дээрээ суулгаж шүүгчийн зөвлөл, 45.5 дээр гишүүнээ орсон байна. Ийм үзэл санааны үүднээс шүүхийн ерөнхий зөвлөл гэдэг зүйлийг бас оруулж ирсэн юм. Тэгээд энэ бас европын бас нэлээдгүй орнуудад ерөнхийдөө бас хэрэглэгддэг механизм байгаа.

За яах вэ зарим европын оронд бол шүүгчдийн холбоо энэ тэр гэж байгаа. Тэгэхээр бас л нэг холбооны ерөнхийлөгч гэдэг юм уу, нэг ийм байнгын бүтэц нь бас эргээд энэ бус байгууллагуудын бас үйл ажиллагааг уялдуулах бас ойлгомжгүй байдал руу оруулчих үүднээс бид нар бас хоёр жил ... /үг тасрав/

Х.Нямбаатар: Батзандан гишүүнээ дэгээрээ яваад, эхлээд хариулангуут та дахиад нэг минут авна.

П.Сайнзориг: 49.5 дээр яг ийм байгаа. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож бусад тавын гишүүдийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно гэсэн. Энэ зарчмын хүрээнд бид нар одоо Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд энэ хуулийн төслүүдийг оруулж ирсэн. Мэдээж бас Улсын Их Хурлын одоо нэр бүхий гишүүдээс өргөн барьсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалыг бас хуулийн төслийг боловсруулах явцдаа харгалзсан байгаа. Өөрөөр хэлэх юм бол анх гишүүдээс өргөн барихдаа бусад таван гишүүдийг бол одоо Байнгын хорооноос томилно гэсэн байдлаар орж ирсэн. Тэгэхдээ энэ бас Байнгын хорооноос зүгээр томилно гэдгийг бид хэд ямар нэгэн шалгуургүйгээр энэ хууль дээр оруулж ирээгүй.

Түрүүн Нямбаатар даргын ярьж байгаа шиг нээлттэйгээр сонгон шалгаруулах энийг одоо олон нийтээс тодорхой одоо шалгуур хангасан нэр дэвшигчид орж ирэх энэ бүх бололцоог нь энэ одоо хууль дээр бас оруулж өгсөн байгаа гэдэг зүйлийг хэлье.

Х.Нямбаатар: Батзандан гишүүний 1 минут, авах уу?

Ж.Батзандан: Бидний өнөөдөр батлах гээд байгаа хэлэлцүүлэгт оруулж байгаа хуулийн гол зорилго бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй шууд холбоотой л гэж би ойлгож байгаа. Энэ шүүгч нарыг сонгон шалгаруулах процессыг илүү өндөрсгөө. Өнөөдөр явж байгаа процесс юу вэ гэхээр шүүхийн ерөнхий зөвлөл гэж нэг байгууллага байдаг. Мэргэжлийн хороо гэж нэг байгууллага байгаа. Тэдэн дээр оноо өгөөд оруулаад ирдэг. Хамгийн өндөр оноо авсан шүүгч нь томилогддоггүй. Хамгийн бага оноо авсан бүлэглэлийн захиалга өгөгдсөн шүүгч томилогддог ийм л байдалтай байгаа шүү дээ. Буд шүүгч ямар олон удаа, ямар өндөр оноо авав. Би одоо гайхаад байдаг юм. Үгүй ээ тэр хүнийг бол ерөөсөө хэзээ ч томилохгүй. Яагаад гэхээр Буд шударга учраас. Зоригт ч Будыг хэзээ ч томилохгүй гэдгээ хэлдэг байсан. Энийг яаж өөрчилсөн юм бэ?

Х.Нямбаатар: Ажлын хэсэг индрийн микрофон Зандраа шүүгч.

О.Зандраа: Батзандан гишүүний асуултад хариулъя. Мэргэжлийн хорооны чиг үүрэг бол өөрчлөгдөж байгаа. Бүтэц бүрдэлгүй өөрчлөгдөж байгаа гэдгийг би түрүүн хэлсэн. Мэргэжлийн хорооны сонгон шалгаруулалт бол шинэ хуулийн дагуу явна. Энэ сонгон шалгаруулалтын үндсэн чиг үүргээр мэргэжлийн хорооны гишүүдийн хариуцаж байгаа ажил үүрэг нь бол хуульчдаас шүүгчдийг шилж олох чиглэлд тусгай болон суурь шалгалтыг авахаар зохицуулалт хийгдсэн байгаа. Суурь шалгалтад нь орох зүйлүүдийг тусгайлан бичсэн. Тусгай шалгалтад орох зүйлүүдийг тус тусад нь бичсэн. Суурь шалгалттай нь тэнд 60 буюу түүнээс дээш оноо аваагүй нэр дэвшигч бол тусгай шалгалтад орохооргүй байхаар ингэж зохицуулсан байгаа. Шинэ хуулийн зохицуулалтаар бол мэргэжлийн хорооны чиг үүрэг өөрчлөгдөж байгаа. Түрүүн би хэлсэн энэтэй холбогдуулаад хуульчдаас шүүгчдийг шилж олох чиг үүрэг нь бол ерөнхий зөвлөлдөө байгаа. Үндсэн чиг үүрэг нь ерөнхий зөвлөл хуульчдаа шүүгчдийг шилж болох үндсэн чиг үүргийг ерөнхий зөвлөл гүйцэтгэдэг. Ерөнхий зөвлөл өөрийн бүтцийн байгууллага болох мэргэжлийн хороогоороо дамжуулж хуульчдаас шилж олох шалгалтыг явуулж байгаа юм. Энэ төслийг хийх явцад бол хоёр өөр санал гарч ирсэн. Ер нь мэргэжлийн хороо гэж байх юм уу, байхгүй юм уу. Нэг хэсэг нь бол байя гэсэн. Байя гэдэг дээр бол олонх болсон учраас мэргэжлийн хороо орж ирсэн. Одоо мэргэжлийн хорооноос түрүүний одоо суурь болон тусгай шалгалт аваад эцсийн дүнгээр нь бол онооны эрэмбийг нь дараалж оруулаад байгаа байхгүй юу одоо. Тэгээд энэ маргаан гарч ирээд байгаа юм. Одоо жишээлбэл 100 онооноос 90 оноо

авсан хүн а шүүгч болдоггүй. 60 оноо авсан хүн шүүгч болчихлоо гэсэн ийм асуудал яригдаж байгаа юм.

Урьд нь ч одоо ерөнхий зөвлөл дээр энэ асуудал яригддаг байсан. Цаашдаа ч одоо яригдах учраас энэ мэргэжлийн хорооны үнэлгээний асуудлыг бол ерөөсөө тэнцсэн, тэнцээгүй гэдгээр нь ангилалд хийж оруулж ирж байгаа юм. Ерөөсөө тэнцсэн бүх хүмүүс нэг гараанаас ерөнхий зөвлөл дээрээ л очъё. Тэрнээс одоо ганц, хоёр онооны зөрүү ганц, хоёр баллын зөрүүтэй одоо тэр хүнийг мэргэжлийн хорооны шалгалтад хамгийн өндөр оноо авсан хүнийг шүүхийн ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид өргөн мэдүүлээ гэх юм бол шүүхийн ерөнхий зөвлөлийн Үндсэн хуулиар олгогдсон нөгөө хуульчдаа шүүгчдийг шилж олох эрх нь өөрөө зөрчигдөх болчихоод байгаа юм. Тийм учраас одоо энэ 5 сарын 25-наас хүчин төгөлдөр болж хэрвээ энэ хууль мөрдөх юм бол энүүгээр байгуулагдсан мэргэжлийн хорооны гишүүд шалгалтаа авна. Тэнцсэн, тэнцээгүй гэдэг үнэлгээ л гаргана. Тэнцсэн бүх улсуудыг бол ерөнхий зөвлөлд оруулж хэлэлцүүлнэ. Тэрэн дотроосоо тэр хуульчдыг шилж олдог эрхийнхээ дагуу ерөнхий зөвлөл нь шүүгчээр хэнийг томилуулах юм гэдэг саналаа Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэхээр байгаа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт өөрчлөлт орж Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг 33-д заасан бүрэн эрхийг олгох юм бол тусгайлсан хуулиар олгоно гэсэн ийм заалт орж ирсэн. Энэтэй холбогдуулаад энэ шүүгч нарын чинь томилгооны асуудал хөндөгдөж эхэлсэн. Одоо яаж байна гэхээр зэрэг үндсэн хуулийн дөчин наймдугаар зүйлд зааснаар шүүгчдийг Ерөнхийлөгч томилж байгаа.

Монгол Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгчийг Ерөнхийлөгч томилж байгаа. Харин одоо танхимын тэргүүн, тус тусын шүүхийн ерөнхий шүүгч нарыг бол одоо тухайн шүүгчдийн зөвлөгөөнөөсөө томилдог болж байгаа. Энэ төслийг бол бид нар анхнаас нь Үндсэн хуулийн оруулсан нэмэлт, өөрчлөлтийнх нь дагуу Хууль зүйн яаман дээр очоод ажлын хэсэг ажиллаад энэ 33-даа дүйцүүлж хийе гэж ийм санал гарсан. Тийм учраас ерөнхий шүүгч, танхимын тэргүүнийг Ерөнхийлөгч томилдог байсан заалт өөрчлөгдөөд тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс ерөнхий шүүгч нарыг томилдог. Ерөнхий шүүгч нь танхимын тэргүүнээ томилдог ийм заалт орж ирсэн.

Энэ бол Үндсэн хуулийн нэмэлт орсон 33-н холбогдох заалттай бол нийцэж байгаа гэсэн байдлаар энэ хуулийн төсөл хийгдсэн. Ер нь тэр бүлэглэл үүссэн янз бүрийн хэрэг маргаан одоо шийдэгдэхгүй байгаа гэдэг асуудал бол жичдээ бас шалгаж шийдэх асуудал байх. Ер нь бол Дээд шүүх дээр ирж байгаа хэргүүд сая нэг хэдэн шүүгчийн бүрэн эрх түдгэлзсэнтэй холбоотой бас иргэний танхим нэлээн гацсан. Одоо бол бүрэлдэхүүн бүрдэж байгаа учраас энэ хэрэг маргааныг хянан шийдвэрлэх үйл ажиллагаандаа явж байгаа. Тэр ... /минут дуусав/

Х.Нямбаатар: Батзандан гишүүн 1 минут.

Ж.Батзандан: Тэгэхээр хуулийн төслийг бол дэмжээд илүү боловсронгуй сайжруулаад явах нь зүйтэй гэж ойлгож байна. Одоо наад улс төрийн нөлөөлөлд ордог шүүхийн тогтолцоог л бид засах ёстой. Бүлэглэлийн нөлөөллөөс шүүхийг аврах ёстой. Бид үнэнээ л ярья одоо яг. Баттулгын үед харьцангуй гайгүй байх болов уу гэж би горьдож байгаа. Баттулга Ерөнхийлөгчөөс хойш ямар юмнууд Ерөнхийлөгч болж гарч ирэхийг хэн ч мэдэхгүй. Элбэгдоржийн үед томилогдсон 200 гаруй шүүгчийн 60 хувь нь Элбэгдоржийн нутгийн хүмүүс байсан. Энэ завхралаас л бид засах гэж энэ хуулийг батлан гаргаж байгаа.

Нэг бол 3 группийн, 3 бизнесийн бүлэглэлийн нөлөөний хүмүүс томилогддог. Одоо Батсууриас эхлээд. Тэр захиргааны Батсуурь чинь Худалдаа хөгжлийн банкны хуулийн зөвлөх байсан. Тэгэхээр энэ завхралыг засахын тулд л бид ... /минут дуусав/

Х.Нямбаатар: Сая Батзандан гишүүн санал хэлчих үү тийм ээ? Санал хэлчихлээ. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Зүгээр яах вэ бид хэд хэдэн зүйл дээр л анхааръя. Өнөөдөр хэлэлцэх эсэхээ шийдээд явчихъя. Батзандан гишүүнээ, Батзандан гишүүнээ энэ хэдүүлээ Байнгын хороон дээр дэгээ сахъя л даа. За хэдүүлээ энэ нэг хуульчдаас шүүгчдийг сонгон шалгаруулдаг байгууллагаа хараат бус болгох дээр л энэ цаашаа энэ төсөл дээр илүү анхаармаар байгаа юм. Тэр хэдхэн төгрөгөөс болж орон тооны бус байдлаар явна хөрөнгө мөнгө хэмнэнэ гэдэг тэр ойлголтоос салах хэрэгтэй. 5 хүний одоо санхүүгийн асуудал аягүй хүнд гэдэг тийм тайлбар бол тайлбар биш байх аа гэж бодож байна.

Хоёрдугаарт бүх шатны ерөнхий шүүгчдийг дотроосоо сонгон шалгаруулж байгаа тохиолдолд энэ хэргийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа одоо хуваарилагдаж ирсэн хэргийг шүүгчдэд хуваарилдаг цахим тэр төхөөрөмжийг маш тодорхой энэ Шүүхийн хуульд тусгамаар байгаа юм. Өөрөөр хэлбэл хэн нэгнээс хамааралгүй байдлаар хэрэг маргааныг шийддэг энэ тогтолцоо руу л явмаар байгаа юм. Өөрөөр хэлбэл цахимаар уналтаар шүүгчдэд хэрэг нь хуваарилагдаж очдог. Тухайн шатны ерөнхий шүүгч бол тэр зохион байгуулалтын шинжтэй бусад захиргааны шинжтэй арга хэмжээгээ авдаг энэ чиглэл рүүгээ. Тойргийн зарчмаар шүүх байгуулагдах тохиолдолд бид нар энийг бас энэ Шүүхийнхээ тухай хуульд нэлээн тодорхой тусгамаар байгаа юм.

Сая бүх гишүүдээс гарч байгаа нэг л санал байна. Тэр мэргэжлийн хороог маш тодорхой байгуулах. Одоо үг хэлнэ шүү дээ энэний дараа. Би нөгөө үг хэлэхгүй, юу асуулт асуух гэхээр үгээ хэлэх гэж байгаа юм. За эцэст нь бол яах вэ тэгээд шүүхийн шийдвэр өөрөө хэрэгждэг л байх тогтолцоог бид нар ярьсан. Тэгээд энэ удаа төсөл боловсруулсан ажлын хэсгийнхэн энийг хойш тавьсан. Энэ юу гэвэл шүүх эрх мэдлийн харьяанд нь энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг аваачъя.

Эрүүгийн болон эрүүгийн хэрэг ял эдлүүлэхээс бусад иргэний болон захиргааны шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг бусад одоо гаднын энэ шүүх эрх мэдэл өндөр хөгжчихсөн улс орнуудын жишгээр хараат бус ийм байдал руу шилжүүлбэ л гэж байгаа юм. Өнөөдөр Ерөнхий сайдын захирамжаар томилогдсон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Ерөнхий сайддаа оногдуулсан ногдуулсан даалгасан захиргааны шүүхийн шийдвэрийг хэзээ ч хэрэгжүүлэх боломжгүй л болж байна.

Өнөөдөр захиргааны болон иргэний шийдвэр гүйцэтгэлийн хувь хэмжээ маш муу байгаа. Тэгэхээр ийм хэдэн зүйлүүд дээр анхааръя. Бид нар сая Батзандан гишүүн, Раднаасэд гишүүний тэр гаргасан саналуудтай санал нэг байгаа. Энэ шүүхийн шүүгчийг сонгон шалгаруулдаг байгууллага нь нэг тусдаа, хараат бус. Тэрийг нь сонгон шалгаруулдаг харьцангуй хараат бус тогтолцоог л хэдүүлээ Байнгын хороо болон тэр бусад субъектүүдээс шалгаруулж авахдаа энэ хууль дээрээ тодорхой бичээд өгчихье. Дараагийнх нь болохоор тэр алдаа эндэгдэл гаргасан шүүгч нарыг хариуцлага тооцдог сахилгын хороог нь бас хараат бус байя гэсэн ийм л зарчим дээр ярьж байгаа шүү дээ. Тэгэхээр тэр нэгдмэл байдлын зарчим гэж байж болохгүй байх. Хараат бус л байх ёстой. Тэгээд гишүүд үгээ хэлбэ. Тэгээд дараа нь санал хураая. Үг хэлэх гишүүд. Ганболд гишүүнээр тасаллаа. Батнасан гишүүн.

О.Батнасан: Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг оруулахад ажиллаж байсан ажлын дэд хэсгээс энд зарим нэг хүмүүс нь харагдахгүй байгаад байна л даа. Яах вэ тэр ажлын дэд хэсэг, ажлын хэсэгтээ оруулаад явцгаана биз. Энэ дээрээ анхаарна биз. Би зүгээр Зандраа шүүгчийн нэг тайлбараас энэ шүүхийн ерөнхий зөвлөл чинь Үндсэн хуулиараа орчихсон заалт. Дээр нь нэг мэргэжлийн хороо гээд нэг юм гаргаад ирлээ дээ. Энд заавал мэргэжлийн хороо байх ёстой шүү. Ингээд салбарлаад байх юм бол нөгөө нэг бие даасан хараат бус тэгээд нөгөө ажил одоо явуулахад нэгдмэл байдлаар явуулдаг ч гэдэг юм уу ийм зарчмууд чинь алдагдаад л байна л даа.

За тэгээд танхимаа бас одоо тэгээд л дотроосоо сонгоно барина гээд ийм зүйлүүд яриад байгаа юм байна. Зүгээр энэ тал дээрээ та нар бол өөрсдөө анхаарна биз. Ер нь шүүх хараат бус байна аа гэдэг чинь шүүхийн эрх зүйн орчныг л сайжруулах шүү дээ. Одоо жинхэнэ алтан боломж. Би та бүгдийг энэ Шүүхийн хуулийн шинэчилсэн найруулгыг хийхэд ямарваа нэгэн даргын даалгаврыг битгий аваасай гэж бодож байгаа юм. Дараа нь ард түмний эрх ашгийг, иргэдийн эрх ашгийг хохироосон шийдвэр гаргачхаад нэг тийм захиалгаар, тийм заалт орчихсон шүү гэж хэлж болохгүй. Шүүхийнхэн бол иргэдтэй тэр юм болгон нь уулзаад байдаггүй байх. Аргагүй дээ бие даасан хараат бус юм чинь. Жинхэнэ уулздаг улсууд нь бид Их Хурлын гишүүд байж байна.

Биднээс л энэ хэргүүдийг асуугаад байдаг. Та нар яагаад шийддэггүй юм бэ л гээд байдаг. Жинхэнэ шийдэх ёстой улсууд нь та нар. Шүүгч нар, шүүхийн байгууллага. Одоо хуулийг чинь сайжруулах гэж байна. Ямарваа нэгэн бүлэглэл энэ

тэр юм бол мэдэхгүй би. Гэхдээ алтан боломж чинь ирж байгаа учраас энэ хуулиа их сайхан гаргаж аваад одоо шударга нийгмийн төлөө ажиллаасай гэж хүсээд байгаа юм та бүхнээс. Ийм зүйл байна, баярлалаа.

Х.Нямбаатар: Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Түрүүн хэний Сайнзориг өөрөө уншихлаа шүү дээ. Үндсэн хуулийн 49.5 гээд. Нээлттэйгээр тавыг шүүгчдийн дотроос ерөнхий зөвлөлийн, тавыг нээлттэйгээр гэдгийг аваачаад хаанаас, хаанаас оруулах вэ гэдгийг ингээд Үндсэн хуулийнхаа хүрээг ингээд томоод хаячхаж байгаа байхгүй юу. Энэ чинь зөрчил гэж хэн нэгэн Цэц рүү юм барьж явах ийм тал үүсэх вий. Нээлттэйгээр таван гишүүнийг сонгоно гэсэн энэ Ерөнхийлөгч, сайд, Байнгын хороо гээд ингээд хайрцаглаад хийчихсэн. Тэгээд энийг яах юм бэ?

Хоёр дахь нэг зүйл яах вэ шүүгчдийн ерөнхий зөвлөл би бас тал талаасаа яг хэсэг бодлоо. Нэг талдаа зөв ч байж магадгүй, нэг талдаа их буруу ч байж магадгүй. Батзандан гишүүний хэлж байгаа үнэн шүү дээ. Эрх барьж байгаа намын дарга ерөнхий шүүгч хоёр болбол шүүхийг удирдах ийм хэмжээний бүтцийг бид нар зурчихсан байна. Одоо энэ дотор. Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүгчдийн зөвлөлөөр чинь дамжаад шүүхийн ерөнхий зөвлөл чинь бүрдэнэ. Тэрүүгээр дамжаад сахилгын хороо чинь гарна. Тэрүүгээр дамжаад мэргэжлийн хороо чинь гарна. Тэгсэн мөртөө ерөнхий шүүгч нь болохоор шүүхийн ерөнхий, шүүгчдийн зөвлөлөөсөө биш Улсын дээд шүүх шүүгчдийнхээ дотроос сонгогддог. Тийм л юм бол ерөнхий шүүгч энэ шүүгчид ерөнхий зөвлөл дотроос нь бас хийгээд ингээд ерөөсөө энэ шүүгч нарынхаа гарт шүүх засаглалаа өгье гэж байгаа болбол ингээд ийм хэлбэр лүү. Аль болохоор олон хүний оролцоотойгоор нөгөө хараат бус, сайн зөв ёс зүйтэй, шударга, мэдлэг чадвартай гэсэн хүнээ сонгож гаргахын тулд аль болохоор олон шүүгчдийг одоо нэг 252-оос дээш хүн л оролцож байж шүүгчдийн ерөнхий зөвлөлийг бүрдүүлэх гээд байна шүү дээ.

Бүх шүүгчдийн 50, 50+1 хувь гэхээр тийм үү. Тэгээд 252 хүний гараар шүүгдээд гарч ирж байгаа хүн болбол бас төгс хүн байх юм гэж. Энэ 252 хүнийг чинь өнөөдөр удирдаж, зохион байгуулж тэр хурлыг чинь зохион байгуулж наана, цаана нь нарийн ширийн муу, сайн юмыг нь хийх энэ чинь өөрөө эргээд ерөнхий шүүгч чинь болчихоод байгаа байхгүй юу. Хамгийн аюултай нь. Ийшээ сэлгэх үү, сэлгэхгүй юу, шагнах уу, шагнахгүй юу. Тэгэх мэргэжлийн хяналт, юу мэргэжлийн хороогоор шалгуулах уу, шалгуулахгүй юу ч гэдэг юм уу? Нэг ийм гарахгүй ийм тойргийг л бид нар зурчхаад байна даа. Би бол энэнээс төгс хувилбарыг өөрөө хэлж чадахгүй байна. Ний нуугүй хэлэхэд. Бас сайн мэдэхгүй байна.

Бид ямар шүүгчийг өнөөдөр ард түмнээс сонгодог болъё гэсэн тийм хууль батлаагүй тийм нөхцөл байхгүйгээс хойш. Тэгэхээр энэ дээрээ бид нар яг энэ баланс

гэх юм уу аль, аль талын харилцан хяналт тэнцвэр энэ юмнуудыг нь бас ажлын хэсэг дээрээ нэлээн ярьж байж яаж хийх юм энийг бас тооцох ёстой байх. Энэ өмгөөлөгч нарыг оролцуулсан, энэ Хуульчдын холбоо гэж байгаа байх одоо эд нарын бас оролцуулсан, холбогдох энэ их, дээд сургуулийн багш нарыг нь оролцуулсан, тэгээд энэ шүүгч нарын төлөөллийг нь оролцуулсан ийм нэг хэлэлцүүлэг онлайн байдлын хэлэлцүүлгийг нь Байнгын хорооноос зохион байгуулбал яадаг юм. Энэ болбол өнөөдөр яг өнгөрсөн 3, 4 жилийн хугацаанд болохгүй, бүтэхгүй юмыг ярьсан энэ шүүхийн системийг шинэчлэх суурь алхам. Бид энэ суурийг л зөв тавьж чадахгүй болбол яг эргээд л нөгөө хуучин юмаа яриад л явна. Хуучин балчиг намагтайгаа зууралдаад хуучин хүмүүсээ ингээд хийгээд явна.

Ийм байдлаас гарах юм уу, үгүй юу гэдэг чинь одоо яг энэ хууль болчхоод байгаа юм. Тэгэхээр энэ хууль дээр болбол бид нар цаг хугацаанд хавчигдахгүй болдоггүй бол нэлээн тавиу төлөвлөгөөтэйгөөр нэлээн олон үе шаттайгаар хэлэлцүүлэг хийх нь зүйтэй болов уу л гэж саналтай байна. Гол нь энэ хараат бус байдал гэдэг юм хүнийг болоод үйл ажиллагааны хувьд хараат бус байдлыг нь бий болгоход л байгаа шүү дээ. Бид нарын гол зорилго бол. Хүнийг боомилоод ингээд хууль зөрчвөл ингэнэ шүү гээд нэг талдаа хашаа бариад хашиж болж байгаа юм шүүгч. Нөгөө талдаа үйл ажиллагааг нь олон нийтийн хяналтад оруулаад ирсэн цагт тэр хүн хэзээ ч хөдөлж чадахааргүй. Хэн нэгэн юм яриад ирэхэд одоо уучлаарай болохгүй юм байна. Энэ чинь ийм учиртай юм гээд хэлээд сууж байх тийм орчин нөхцөлийг бүрдүүлж бас тийм үйл ажиллагааг нь олон нийтийн оролцоо руу оруулахгүй болбол өнөөдрийн нөхцөл байдал дээр болбол яг нэг их айхавтар энэ хууль гарснаар болбол бид нар төгс хараат бус байдлыг бол хэзээ ч хаана ч бий болгож чадахгүй.

Ийм л дүр зураг өнөөдөр яг энэ хуулийн төслийг унших явцад харагдлаа. Тэгээд ажлын хэсэг ажиллах байх. Тэгэхээр энэ дээр бас тодорхой саналуудаа гаргаж нарийвчлан гаргаж өгнө гэж бодож байна.

Х.Нямбаатар: Ганболд гишүүний микрофоныг өгье.

Д.Ганболд: Баярлалаа. Тэгэхээр сая гишүүд маань ч бас нэлээдгүй хариуцлагатай бас асуудалд хандахыг бас шаардаж байна л даа. Би бол юу хэлэх гэж байна вэ гэхээр зэрэг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж гарч ирж байгаа энэ Шүүхийн тухай хууль гэдэг бол магадгүй бид энэ зах зээлийн нийгмийг байгуулж байгаа гэдэг юм уу, яг одоо үнэн чанартай үед бид капиталист нимийг л байгуулж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ нийгмийг байгуулж байгаа хүрээнд магадгүй хуульчдаас нь асуух юм бол эрх зүйт төрийг бид байгуулж байна гэж ярьдаг. Тэгвэл яг эрх зүйт төрийг чинь үндсэн цөм болсон суурь нь одоо яах аргагүй энэ Шүүхийн тухай хуулийг бид төгс боловсронгуй болгохгүй юм бол 30 жил бид явж ирсэн энэ завхралыг арилгаж чадахгүй ийм хэмжээний торгон агшин дээр л ирчихсэн байгаа. Одоо бид яг энэ хуулиар цаашдаа Монгол Улс зөв хөгжих үү, үгүй юу, эрх зүйт төр гэдгийн цаана хууль, хуулийг дээдлэх. Хуулийг дээдлэх гэдгийн цаана ёс зүйтэй байх. Бид мянга сайхан хууль гаргаад ёс зүйгүй ёс суртахуунгүй байгаа үед хэзээ ч бид нийгмийг зөв байр сууринд аваачиж чадахгүй. Улс орон ч олигтой хөгжихгүй.

Магадгүй саяын одоо бид нарын энэ гишүүдийн ярьж байгаа дотор одоо юу гэдэг юм нэг 50 дээр нэмэх нь гэдэг юм уу ердийн олонхоор гэж яриад байгаа дээр миний хувьд бол санал нийлмээргүй байна. Үнэхээр 500 юм уу за 1000 хүрэхгүй шүүгчтэй бол тэр дундаасаа шударгаар шүүж байгаад үнэхээр одоо энэ олон талт одоо үйл ажиллагааг нь зохицуулах ялангуяа тэр мэргэжлийн хороо за цаашлаад ерөнхий зөвлөлөөс нь авхуулаад үнэхээр зөв тогтолцоог нь бүрдүүлж өгөхгүй юм бол бид өнөөдрийг хүртэл нийгэмд шийдэж чадаагүй, хууль шүүхийн байгууллагаар ороод одоо хүртэл шийдэж чадаагүй маш олон хэрэг байна шүү дээ. Энэний ард дандаа яах нь вэ нөгөө бие даасан эсвэл одоо хэн нэгний хараат бус гээд юм яриад байдаг нэгэнт л хүн байгаа учраас цаана нэг нь аль нэгэн талд нь нөлөөлөл орж ирээд байдаг. Оруулахгүй байх зарчим нь аль болохоор энэ салбарыг бие даалгахдаа үнэхээр тэр 100 хувь хамруулсан тэр шүүгчдээс нь, тэр өмгөөлөгчдөөс нь, тэр холбоонуудаас нь нийлсэн санал бодлыг нь нэгтгэж авч байгаад тэр дундаас хамгийн сайн шалгарсан за тэр дотроо би бол мэргэжил гэдэг талаас нь илүүтэйгээр ёс зүйтэй. Ёс зүй гэдэг юм байхгүй учраас Монгол Улс нуран унаж байна шүү дээ өнөөдөр. Өнөөдөр магадгүй улс төрчид нь гэдэг юм уу, бид байнгын чичлүүлж байгаа. Иргэдтэй очоод уулзахад үгүй ээ тэр хэрэг юу болсон юм бэ, тэр асуудлыг шийдсэн үү, шийддэг газар нь хууль шүүхийн байгууллага шүү дээ. Хэдийг нь шийдээд өнөөдөр цэгцэлсэн бэ? Би дахиад энд ингээд асуух юм бол наад зах нь гэхэд л одоо гадна, дотно мөнгөний урсгал явсан оффшороос нь авхуулаад, энэ томоохон бусад хэргүүд бүгд замхраад өнөөдөр шийдсэн нь хэн байгаа юм бэ?

Магадгүй зарим нэг нь улс төрчид нь попорсон гэдэг юм уу сайн, муу нэр зүүгээд чичлүүлээд явж байгаа улс төрчид нь магадгүй их олонх болсон. Эргээд иргэд юм уу, тэрийг нэхэж байгаа иргэн олон түмэн бид нараас нэхдэг. Шүүх хуулийн байгууллага нь болбол бие даасан хараат бус гэдэг зайнд бас өөрийгөө халхавчилчихаад энэ орон зай чинь өнөөдөр төгс хэрэгжихгүй байгаад байгаа юм.

Тийм учраас энэ ажлын хэсэг зүгээр одоо Хууль зүйн байнгын хорооноос биш Их Хурлын даргын нэр дээр ажлын хэсэг гаргах юм байна. Шаардлагатай бол одоо бас тодорхой хэмжээнд би өөрөө бас орох хүсэлтэй байна. Хууль хүчний байгууллагыг төгс боловсронгуй, эрх зүйн орчныг нь бүрдүүлж өгч байж сая энэ улс хөгжих юм. Тэгэхгүй бол одоо бас болохгүй юм гэдэг дээр. Тэгээд энэ асуудлыг хэлэлцэх нь зүйтэй. Тэгээд цаашаагаа их чухал юм шүү гэдгийг хэлье.

Х.Нямбаатар: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хурааа. Хэлэлцэх эсэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад оролцсон гишүүдийн 60 хувийн саналаар Шүүхийн тухай шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэх эсэхийг дэмжлээ. Сая уншсан шүү дээ би. Дараагийн асуудалдаа оръё. Байна.